



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 667

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй нийт 9,165,300.00 /есөн сая нэг зуун жаран таван мянга гурван зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан чиргүүл, автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сүмбэрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан үндсэн хөрөнгийг сургалтын дадлагын хичээлд ашиглахаар байгууллагадаа үлдээж, эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
6.6.7 дугаар тогтоолын хавсралт



Дорнод аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Чиргүүл 2П5-5 /Зил 130/, 40-64 ТЧ, арал№270744	2002/ 2002	361,800.00
2	Жиангхуай, 70-94 ДОО, жижиг ачааны машин, арал№LJ11КААВ476019531	2007/ 2007	8,803,500.00
	Нийт дүн		9,165,300.00 /есөн сая нэг зуун жаран таван мянга гурван зуун/